БЭЙКЕР ТИЛЛИ
ДАЛАЙВАН АУДИТ
Аудит, баталгаажуулалт, зөвлөх үйлчилгээ

Монгол Улс, Улаанбаатар хот-16066
Баянгол дүүрэг, Амарсанаагийн гудамж-5
Утас: 70005401, 70005402
Э.Шуудан: info@btdalaivanaudit.mn
Вэб хуудас: www.btdalaivanaudit.mn

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

**“ЭРДЭНЭТ АВТО ЗАМ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД**

Дүгнэлт

Бид 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “Эрдэнэт авто зам” ХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр “Эрдэнэт авто зам” ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Сангийн сайдаас баталсан санхүүгийн тайлан гаргах, нягтлан бодох бүртгэл хөтлөх заавар, журам, аргачлалын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (Хараат бус байдлын олон улсын стандартыг багтаасан)-н дагуу компаниас хараат бус байж, эдгээр ёс зүйн шаардлагууд, НБЁЗОУСЗ-ийн дүрэмд нийцсэн ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудиторын санал дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

**Аудитын гол асуудлууд**

Аудитын гол асуудал нь тайлант жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитад хамгийн чухал нөлөөтэй гэж бидний мэргэжлийн шийдлээр авч үзсэн асуудлууд болно. Аудитын гол асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудитын дүгнэлтээ илэрхийлэхдээ бүхэлд нь авч үзсэн бөгөөд аудитын явцад гол асуудлыг тусад нь илэрхийлээгүй болно.

**Бусад асуудал**

Хувьцаат компани нь үйл ажиллагаагаа тайлант хугацаанд эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн дутагдлаас шалтгаалан явуулаагүй байна. Компанийн үйл ажиллагааг цаашид тасралтгүй явуулахад компанийн хувьцаа эзэмшигчид болон төлөөлөн удирдах зөвлөл анхаарч ажиллах шаардлагатай байна.

**Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан багтаагүй байж болох ба бид бусад мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

**Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага**

Удирдлага нь СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийн талаар нэмэлт тодруулга хийнэ.

Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

**Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага**

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- ✓ Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Гэхдээ алдаанаас бус компанийн үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.

"BAKER TILLY DALAIVAN AUDIT" LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН
**(үргэлжлэл)**

- ✓ Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- ✓ Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- ✓ Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхад материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.
- ✓ Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлуудын талаар ярилцсан.

Засаглах удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээлэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

**Бусад**

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан бэлтгэсэн бөгөөд бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.

УЛААНБААТАР ХОТ

**БЭЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ ХХК**
**УЛААНБААТАР ХОТ**
**МОНГОЛ УЛС**

**2025 ОНЫ 04 ДҮГЭЭР**
**САРЫН 21-НЫ ӨДӨР**

# САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

*(төгрөгөөр)*

| Үзүүлэлт | 2024.12.31 үлдэгдэл | 2023.12.31 үлдэгдэл |
|---|---|---|
| **Хөрөнгө** | | |
| **Эргэлтийн хөрөнгө** | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | | |
| Дансны авлага | 28,431,980 | 30,044,940 |
| Татвар, НДШ-ийн авлага | 35,500,000 | 35,500,000 |
| Бусад авлага | - | - |
| Бусад санхүүгийн хөрөнгө | - | - |
| Бараа материал | - | - |
| Урьдчилж төлсөн зардал | - | - |
| Бусад эргэлтийн хөрөнгө | - | - |
| *Эргэлтийн хөрөнгийн дүн* | 98,000 | 98,000 |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | **64,029,980** | **65,642,940** |
| Үндсэн хөрөнгө | | |
| Биет бус хөрөнгө | 116,020,000 | 116,020,000 |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | - | - |
| Бусад эргэлтийн бус хөрөнгө | - | - |
| Дуусаагүй барилга | - | - |
| *Эргэлтийн бус хөрөнгийн дүн* | | - |
| **Нийт хөрөнгийн дүн** | **116,020,000** | **116,020,000** |
| | **180,049,980** | **181,662,940** |
| **Өр төлбөр ба эздийн өмч** | | |
| **Өр төлбөр** | | |
| Дансны өглөг | | |
| Цалингийн өглөг | - | - |
| Татварын өр | - | - |
| НДШ-ийн өглөг | 8,822,739 | 8,955,885 |
| Богино хугацаат зээл | - | - |
| Ногдол ашгийн өглөг | - | - |
| Урьдчилж орсон орлого | - | - |
| Бусад богино хугацаат өр төлбөр | - | - |
| *Богино хугацаат өр төлбөрийн дүн* | - | - |
| Урт хугацаат зээл | **8,822,739** | **8,955,885** |
| Хойшлогдсон татварын өр | | |
| Бусад урт хугацаат өглөг | | |
| **Өр төлбөрийн нийт дүн** | | |
| **Эздийн өмч** | **8,822,739** | **8,955,885** |
| Өмч:-Хувийн | | |
| Нэмж төлөгдсөн капитал | 168,090,800 | 168,090,800 |
| Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг | - | - |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | - | - |
| Хуримтлагдсан ашиг | - | - |
| **Эздийн өмчийн дүн** | 3,136,441 | 4,616,255 |
| **Өр төлбөр ба эздийн өмчийн дүн** | **171,227,241** | **172,707,055** |
| | **180,049,980** | **181,662,940** |

"BAKER TILLY DALAIVAN AUDIT" LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

*Хавсаргасан тайлангууд нь энэхүү хараат бус аудитын дүгнэлтийн салшгүй хэсэг болно.*

## ОРЛОГО ҮР ДҮН БОЛОН
## БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

*(төгрөгөөр)*

| Үзүүлэлт | Тайлант оны | Өмнөх оны |
|---|---|---|
| **Борлуулалтын орлого (цэвэр)** | - | 50,000,000 |
| Борлуулалтын өртөг | - | 36,479,800 |
| ***Нийт ашиг*** | - | ***13,520,200*** |
| Түрээсийн орлого | - | - |
| Хүүний орлого | - | - |
| Ногдол ашгийн орлого | - | - |
| Эрхийн шимтгэлийн орлого | - | - |
| Бусад орлого | - | - |
| Борлуулалт маркетингийн зардал | - | - |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 1,479,814 | 10,931,053 |
| Санхүүгийн зардал | - | - |
| Бусад зардал | - | - |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | - | - |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | - | - |
| Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | - | - |
| Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз) | - | - |
| Бусад ашиг алдагдал | - | - |
| ***Татвар төлөхийн өмнөх ашиг*** | **(1,479,814)** | **2,589,147** |
| Орлогын татварын зардал | - | (6,745,892) |
| ***Татварын дараах ашиг*** | ***(1,479,814)*** | ***(4,156,745)*** |
| Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг | | |
| ***Тайлант үеийн цэвэр ашиг*** | ***(1,479,814)*** | ***(4,156,745)*** |

*Хавсаргасан тайлангууд нь энэхүү хараат бус аудитын дүгнэлтийн салшгүй хэсэг болно.*

"BAKER TILLY DALAIVAN AUDIT" LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

**ЭРДЭНЭТ АВТО ЗАМ ХК**

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон жилийн*

# ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

*(төгрөгөөр)*

| Үзүүлэлт | Өмч | Эздийн өмчийн бусад хэсэг | Нэмж төлөгдсөн капитал | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **2022 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл** | **168,090,800** | - | - | **8,773,000** | **176,863,800** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | |
| **Залруулсан үлдэгдэл** | **168,090,800** | - | - | **8,773,000** | **176,863,800** |
| Тайлант үеийн цэвэр ашиг | | | | | |
| Бусад орлого | | | | (4,156,745) | (4,156,745) |
| Өмчид гарсан өөрчлөлт | | | | | |
| Зарласан ногдол ашиг | | | | | - |
| **2023 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл** | **168,090,800** | - | - | **4,616,255** | **172,707,055** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | |
| **Залруулсан үлдэгдэл** | **168,090,800** | - | - | **4,616,255** | **172,707,055** |
| Бусад орлого | | | | | |
| Тайлант үеийн цэвэр ашиг | | | | | |
| Өмчид гарсан өөрчлөлт | | | | (1,479,814) | (1,479,814) |
| Зарласан ногдол ашиг | | | | | - |
| **2024 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл** | **168,090,800** | - | - | **3,136,441** | **171,227,241** |

"BAKER TILLY DALAIVAN AUDIT" LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

*Хавсаргасан тайлангууд нь энэхүү хараат бус аудитын дүгнэлтийн салшгүй хэсэг болно.*

## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

*(төгрөгөөр)*

| Үзүүлэлт | Тайлант оны | Өмнөх оны |
|---|---|---|
| ***Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ*** | | |
| *Мөнгөн орлогын дүн /+/* | - | **50,000,000** |
| Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого | - | 50,000,000 |
| Туслах үйл ажиллагааны мөнгөн орлого | - | - |
| Буцаан авсан албан татвар | - | - |
| Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгөн | - | - |
| Бусад мөнгөн орлого | - | - |
| *Мөнгөн зарлагын дүн /-/* | **1,612,960** | **20,849,560** |
| Ажиллагсад олгосон мөнгө | - | - |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө | - | - |
| Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө | - | - |
| Ашиглалтын зардалд төлсөн мөнгө | - | 809,700 |
| Түлш, шатахуун, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө | - | - |
| Хүүний төлбөрт төлсөн | - | - |
| Татварын байгууллагад төлсөн мөнгө | 148,360 | 17,339,860 |
| Даатгалын төлбөрт төлсөн | - | - |
| Бусад зардал | 1,464,600 | 2,700,000 |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(1,612,960)** | **29,150,440** |
| ***Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ*** | | |
| *Мөнгөн орлогын дүн /+/* | - | - |
| Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого | - | - |
| Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | - | - |
| Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | - | - |
| Хүлээн авсан хүүний орлого | - | - |
| Хүлээн авсан ногдол ашиг | - | - |
| *Мөнгөн зарлагын дүн /-/* | - | - |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө | - | - |
| Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө | - | - |
| Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | - | - |
| Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | - | - |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | - | - |
| ***Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ*** | | |
| *Мөнгөн орлогын дүн /+/* | - | - |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | | |
| Хувь болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | - | - |
| Төрөл бүрийн хандив | - | - |
| Бусад мөнгөн орлого | - | - |
| *Мөнгөн зарлагын дүн /-/* | - | - |
| Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | - | - |
| Санхүүгийн түрээсийн төлбөрт төлсөн | - | - |
| Төлсөн ногдол ашиг | - | - |
| Төрөл бүрийн хандив | - | - |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | - | - |
| Валютын ханшийн зөрүү | - | - |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **(1,612,960)** | **29,150,440** |
| *Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл* | **30,044,940** | **894,500** |
| *Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл* | **28,431,980** | **30,044,940** |

"BAKER TILLY DALAIVAN AUDIT" LLC CERTIFIED ACCOUNTING, AUDITING & APPRAISAL

*Хавсаргасан тайлангууд нь энэхүү хараат бус аудитын дүгнэлтийн салшгүй хэсэг болно.*